


ЗЭС, ХАЙЛУУР ЖОНШНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Д.Галсандорж*

Дэлхийн зэс, жоншны үйлдвэрлэл, хэрэглээ

Манай улсын уул уурхайн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний олон улсын өрсөлдөх чадавхийг зэс ба жоншны баяжмалын жишээн дээр авч үзье. Олон улсын байгууллагуудын гаргасан судалгаагаар өнөөдөр дэлхийн цэвэр зэсийн нөөцийг батлагдсан үйлдвэрлэлийн зэрэг ба прогнозыг нь оруулаад тооцоход 650 сая тонн байгаа.

Дэлхийн зэсийн нөөц, сая.тн



Илрүүлсэн энэ нөөц нь дэлхийн 30 жилийн хэрэглээг хангах бөгөөд үүнээс өнөөдөр дэлхийн улс орнууд жилд 20 сая тонн цэвэр зэс үйлдвэрлэн хэрэглэж байна.

“Эрдэнэт” үйлдвэрийн хувьд анх 1982 онд бүрэн хүч чадлаар ашиглалтад орох үедээ нэгж хүч чадлаар дэлхийн 10 том үйлдвэрийн нэг байсан бол өнөөдөр 40-д орж байна. Өнөөдөр 550 мянган тонн зэсийн баяжмал буюу 130 мянган тонн цэвэр зэс үйлдвэрлэж байна. Эрдэнэт үйлдвэрийн нөөц гэвэл 1,5 тэрбум тонн хүдэр буюу 7,5 сая тонн цэвэр зэс гэж байсан, үүнээс өнгөрсөн 30 жилийн хугацаанд ашигласныг хасч тооцоход одоо 4 сая тонн цэвэр зэсийн нөөц үлдээд байна.

Оюутолгойн ордыг 2,5 тэрбум тонн зэсийн хүдрийн нөөцтэй. Эрдэс Баялаг Эрчим Хүчний Яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл уг орд, тухайлбал ил ба далд уурхайнуудын нөөцийн тайланг баталснаар 26 сая тонн цэвэр зэсийн нөөцтэй гэж гарч байсныг нэмж тооцоод 30 сая тонн болсон байгаа. Үүгээр Оюутолгой яах аргагүй зэсийн нөөцөөрөө Чилийн улсын үйлдвэр “Чикучамага” уурхайн даргаагаар дэлхийд хоёрт орж байгаа.

* Д.Галсандорж - Монголын Экспортлогчдын Холбооны Ерөнхийлөгч, профессор, Монгол Улсын уул уурхайн зөвлөх инженер

Уг ордын ашиглалтын явцад ямар технологи нэвтрүүлэх, зэсийн захын агуулга ба металл авалт нь хэдий хэмжээнд байх, хүч чадал, өөрийн өртөг болон хэдэн жилд ашиглах зэрэг хүчин зүйлүүдээс нөөцийн тоо хэмжээ шууд шалтгаална гэж олон улсын зах зээлийн мэргэжилтнүүд үзэж байна. Дэлхийн зэсийн хэрэглээний дийлэнх нь буюу 54 хувь нь Ази тивийн орнуудад ногдож байна.

Дэлхийн цэвэр зэсийн хэрэглээ, тивээр, мян.тн-оор


Тивээр	2004 он	2007 он	2008 он	2010 он
Америк	3644	3225	3123	3078
Ази	8173	9359	9950	10813
Европ	4838	4912	4862	4633
Африк	207	275	345	456
Дэлхийн нийт хэрэглээ	17029	17919	18474	19437

Ази тивийн зэсийн хэрэглээний хувийн жин, орноор


Улсаар	1976	1992	2004	2008
Хятад	19%	23%	43%	49%
Тайвань	2%	11%	8%	6%
Япон	63%	37%	15%	12%
Өмнөд Солонгос	3%	9%	11%	7%
Энэтхэг	3.5%	3.5%	4%	6%

БНХАУ хэдэн жилийн өмнө дэлхийн зэсийн номер нэг хэрэглэгч болж АНУ-ыг гүйцсэн. Одоо хэрэглээгээр Хятад нэгд, АНУ хоёрт, гуравт Япон, тэгээд Европ орж байна. Азийн хувьд Хятад, Тайвань зэсийн нийт хэрэглээний 60 хувийг эзэлж, дараа нь Япон, БНСУ орж байна. Энэтхэг улсын зэсийн хэрэглээ сүүлийн үед маш эрчимтэй өсч байгаа.

Дэлхийн зэсийн баяжмалын худалдаанд манай улс 550 мянган тонныг 100 хувь урд хөршид экспортлож байгаа нь дэлхийн зэсийн баяжмалын худалдааны гурван хувийг эзэлж, Чили, Австрали, Индонез ба Хятадын дараа орж байгаа.

Дэлхийн ээсийн баяжмалын худалдаа**Жоншны үйлдвэрлэл худалдаа**

Жоншны тухайд манай улс жилд 350-400 мянган тонн баяжмал үйлдвэрлэж, энэ нь дэлхийн үйлдвэрлэлийн 10 хувийг эзэлж байна.

Дэлхийн жоншны үйлдвэрлэл /хувиар/

Үүнээс “Монросцветмет” ХХК нь манай улсын экспортын 50 гаруй хувийг гаргадаг. Үүн дотор яг дэлхийн стандартад нийцсэн, эцсийн бүтээгдэхүүн болох 95-97 хувийн агуулгатай жоншны баяжмал 130 мянган тонныг Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр үйлдвэрлэж ОХУ, АНУ, Украин болон Тайланд зэрэг оронд экспортлож байна.

Сүүлийн жилүүдэд Хятадын хөрөнгө оруулалттай, жилд 5-10 мянган тонн жоншны баяжмал үйлдвэрлэх улирлын чанартай хувийн хэвшлийн 3 үйлдвэр Багануур, Даланжаргаланд ажиллаж байна. Хувийн хэвшлийн компаниуд 75-95 хувийн агуулгатай металлургийн жонш олборлож байна.

Монгол Улс хайлуур жонш олборлолтоор Хятад, Мексик ба Өмнөд Африкийн дараа 4-д явж байна. Уг нь бидэнд олборлолт, үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх нөөц бололцоо их байгаа.

75-85 хувийн агуулгатай жоншны баяжмал нь металлургийн үйлдвэрүүдийн гол түүхий эд болдог. Энэ жонш металл хайлуулалтыг түргэсгэж, цахилгааны зарцуулалтыг бууруулдаг. 95 хувийн агуулгатай жоншны баяжмалыг химийн болон хөнгөн цагаан, үйлдвэрүүдийн гол

түүхий эд болдог. Жишээ нь ОХУ, АНУ-ын химийн ба хөнгөн цагааны үйлдвэрүүдэд, мөн атомын салбарын үйлдвэрүүдэд бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигладаг. “Монголросцветмет” ХХК-ийн харьяа Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэр жоншныхоо 80 хувийг хойд хөрш болон Украинд, үлдэх хувийг зах зээлийн үнэ, эрэлт хэрэгцээнээс шалтгаалаад Америк, Тайвань ба Тайландад гаргаж байгаа. Жоншны хэрэглээ дэлхий дээр маш их өсч байгаа. Өнгөрсөн санхүүгийн хямралын жилүүдэд дэлхийн томоохон хэрэглэгч ОХУ болон АНУ-ын хими, металлургийн үйлдвэрүүд уналтад орсон боловч одоо эргээд хэрэглээ хурдацтай өсч байна.

Эдгээр орнуудаас 2011 онд 95-97 хувийн агуулгатай жонш 200 гаруй мянган тонныг авах захиалга ирсэн, Монголын баяжуулах үйлдвэрүүд эдгээр захиалгыг хангах боломж бага байгаа.

Жоншны нөөц дэлхий дээр их ховордож байгаа. Орлуулах түүхий эд байдаггүй, цаашдаа дэлхийн орнуудын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахад ихээхэн хүндрэлтэй болж байна.

Манай улсад өнөөдөр экспортын зохицуулалт байхгүй гэж хэлж болно. Экспортлож байгаа эрдэс түүхий эд, бүтээгдэхүүнд гаалийн татвар ногдуулдаггүй. Гадаад харилцаа болон Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны хүрээнд “Худалдааны зохицуулалтын тухай хууль” гаргахаар ажиллаж байгаа. Гэтэл манай хоёр хөрш Гадаад худалдааны зохицуулалтын маш тодорхой хуультай олон жил мөрдөж байна. Жишээ нь жоншны баяжмал гаргалаа гэхэд Хятад улс 15 хувийн экспортын гаалийн татвар авдаг. Мөн 2010 онд 400 мянган тонныг гаргана гэсэн тогтоосон квоттой. Экспорт хийдэг компаниуддаа зөвшөөрөл, сертификат олгодог нарийн зохицуулалттай. Яагаад гэвэл энэ түүхий эд дэлхий дээр ховордчихсон. Тиймээс Хятад улс жоншны зах зээлийн үнийг тогтвортой байлгаж чаддаг, өсгөж ч чадаж байгаа. 2010 онд жоншны баяжмалын үнэ нь өссөн, ирэх онд 20 орчим хувиар өсөх хандлагатай байгаа. Хятад улс өмнө нь 2 сая тонн, 2005 онд 1,1 сая тонн жоншны баяжмал гаргаж байсан бол одоо дотоодынхоо үйлдвэрүүдийн хэмжээг түүхий эдээр бүрэн хангах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бодлогын хүрээнд экспортын хэмжээгээ багасгаж байна. Гэтэл манайд ямар ч зохицуулалт байхгүй, экспортын татвар ч байхгүй. Тэгээд ч манайх жоншыг түүхийгээр 30 хувийн агуулгатай хүдэр хэлбэрээр гаргаад Орос болон Хятадын баяжуулах үйлдвэрүүдийг ажиллуулаад байдаг.

Хойд хөрш ОХУ Хятадтай адил, мөн нарийн зохицуулалттай хуультай, импортын өндөр татвартай. Гэхдээ тэнд эрэлт хэрэгцээ өндөр байгаа учраас манай улс ОХУ-д жоншоо өндөр үнээр өгч байгаа. Зэс ба алтны олон улсын худалдааг биржүүд мөн зохицуулдаг. Жишээ нь, Лондонгийн алт, мөнгөний бирж дээр алт, мөнгөний үнийг тогтоож, чанар, стандартыг гаргаж байна. Лондонгийн металлын бирж (ЛМБ) дээр зэсийн үнийг тогтоож, хайлах, цэвэршүүлэх үйлдвэрүүдийг бүртгэж чанарын гэрчилгээ олгож байна.

Өдөр бүр ЛМБ-д зэсийн үнийг тухайн өдөр, сар, 3, 9 ба 27 сарынх нь дундаж үнийг тогтоож байгаа. Чили, Канад, Австралийн зэсийн томоохон

үйлдвэрүүдийн өөрийн бүрэн өртөг зардал нэг тонн цэвэр зэс гаргахад 1500-1900 ам.доллар байна. Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт” төрийн өмчит үйлдвэр болохоор зардал их өндөр, тонн нь бараг 3000 ам.долларын өөрийн өртөгтэй байдаг. Зөрүү нь хэд байна вэ. Үүн дээр манайх 68 хувийн татвар авч байна. Саяхан Сангийн яамнаас бас зэсийн үнийн өсөн нэмэгдсэн нөөц ашигласны татвар ногдуулчихсан байгаа. Энэ бүхэн нь олон улсын механизмд нийцэж, тохирч байна уу. Энэ нь экспортын эрдсийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварын бууруулж байна. Гэтэл олон улсын биржийн агуулахууд дэлхийг тойроод байж л байна. Мөн химийн шинжилгээ хийдэг лабораториуд ч байна. Гэтэл манайд биржийн стандартад хүрсэн нэг ч лаборатори алга, Замын-Үүд дээр ч байхгүй.

Биржийн бус түүхий эд буюу гянт болд, молибден, нүүрс, хайлуур жонш ба төмрийн хүдрийн үнийг томоохон үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн үнийг харгалзан тогтоодог. Харин Лондонгийн металлын бирж дээр цэвэр зэс 99.99%-ийн агуулгатай байна, хэмжээ нь 25 кг байна гэх мэтээр зэс зэрэг бусад түүхий эдийн чанарын стандартыг гаргачихаж байна. Манай эрдэс түүхий эд, бүтээгдэхүүн ийм стандарт болон итгэмжлэл аваагүй, түүнд хамрагдаагүйгээс манай цэвэр зэсийг зүгээр л барилга, дэд бүтцийн ахуйн зориулалтаар хэрэглэнэ үү гэхээс биш, авто машин, онгоцны үйлдвэрлэлд (“Мерседес”, “BMW”, “Бионг” болон “Айробус” зэрэгт) хэрэглэхэд тохирдоггүй. Яагаад гэвэл цахилгаан дамжуулах чанар, бат бөх зэрэг 5 гол үзүүлэлтээс зөвхөн 2-ыг нь хангаж чаддаггүйгээс тэр.

Монголын худалдаа

Монгол Улсын гадаад худалдаа эрчимтэй өсч байна. 2010 оны 11 дүгээр сарын байдлаар экспорт 2,5 тэрбумд хүрсэн.

Уул уурхайн гол нэрийн барааны экспорт, сая ам.доллар

№	Төрөл	Хэмжих нэгж	2007		2008		2009		2010 оны эхний 11 сараар	
			тоо хэмжээ	Орлого	тоо хэмжээ	Орлого	тоо хэмжээ	Орлого	тоо хэмжээ	Орлого
1.	Алт	тн	11.6	34.9	22.1	99.9	11.7	335.9	4.7	165.2
2.	Зэс	мян.тн	607.8	811.5	582.9	835.7	586.9	501.8	518.0	688.7
3.	Жонш	мян.тн	360.0	44.9	348.8	59.2	147.0	29.7	346.0	57.6
4.	Төмрийн хүдэр	мян.тн	240.4	16.5	1,013.1	92.3	1,576.1	86.7	3,123.5	216.9
5.	Цайр	мян.тн	132.6	75.9	137.5	54.6	150.7	122.5	100.0	110.7

Энэ дотор алт, зэс, цайр, төмрийн хүдэр, жонш, нүүрс зэрэг гол 6 нэр төрлийн бүтээгдэхүүн өсч, экспорт нь нэг тэрбум 973 сая ам.долларт хүрч, нийт экспортын 77.4 хувь, бусад эрдэс түүхий эдийг оролцуулаад 80 гаруй хувийг эзэлж байна. Нүүрсний экспорт ч мөн адил өсч, 2010 онд

18 сая тонныг экспортлосон буюу түүний орлого нь 734 сая ам.долларт хүрээд байна.

Манай улс хоёр хөршийн дунд байдаг, далайд гарцгүй учир эрдэс түүхий эдийн дийлэнх нь Хятад руу гарч байна. Хэрэглээ ч ер нь тэнд байгаа. Цаашаагаа гаргахад манай бүтээгдэхүүн тээврийнхээ зардлыг даадаггүй. Тэгээд ч манай зэсийн баяжмал 24 хувийн агуулгатай, бусад нь шороо тээвэрлэж байна. “Эрдэнэт” үйлдвэр хүртэл жилийн гэрээг барууны худалдааны зуучлагч компаниудтай хийгээд зэсийн баяжмалаа бүгдийг нь Хятад руу гаргаж байна. Цайр гэхэд л үйлдвэрийн хувьцааны дийлэнх нь хятадуудын мэдэлд байдаг учир мөн 100% урагшаа гаргаж байна. ТУЗ-д нь хятадууд байдаг учир үнийн бодлогыг тэд барьж, тогтоож байна. Цэвэр зэсийн хувьд өндөр өртөгтэй, тээврийн зардлаа даах учраас Хятадаас гадна БНСУ болон Америк руу гаргаж байна. Алт мөн адил өндөр үнэтэй байгаа учраас АНУ, Англи руу экспортлож чадаж байна. Гэхдээ түрүү хэлснээр алтны тушаалт 4,7 тонн болж илт буурсан. Хувийн компаниуд алтаа тушаахгүй байгаа. Хилээр хууль бусаар гарч байгаа нь ч бий байх, Гэнэгийн ашгийн татварын тухай хууль 2011 оны нэгдүгээр сарын 1-нээр дуусгавар болсон болохоор алтны тушаалтын тоо хэмжээ нэмэгдэх байх гэж найдаж байгаа. Төмрийн хүдрийн баяжмал мөн ялгаагүй, 60 хувийн агуулгатай дийлэнх нь Хятад руу явж байна. Жоншны хувьд өндөр чанартай, өртөгөө дааж чадаж байгаа учир ОХУ, Америк руу гарч байгаа.

Эрдэс түүхий эдийн боловсруулалтын тухайд түвшинг дээшлүүлэх, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг төрөөс ихээхэн дэмжих хэрэгтэй байна. Энэ талаар ЭБЭХЯ “Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх” бодлогын баримт бичгийг боловсруулаад Засгийн газар, УИХ-д оруулчихсан байгаа гэсэн. Энд хэрэв эцсийн бүтээгдэхүүн гаргавал төр, засаг ямар урамшуулал, дэмжлэг үзүүлэх юм бэ гэдэг чухал. Сангийн яам үнийн өсөлтийн нэмэгдсэн татвар гэж уул уурхайн чиглэлээр ажиллаж байгаа эрдэмтэд, мэргэжилтнүүд, хүрээлэнгийн саналыг нь аваагүй тогтоочихсон, одоо хэрэгжиж байна.

Жоншны хувьд “Монголпросцветмет” олон улсын худалдааны зарчмыг барьж дэлхийн зах зээлийн үнээр өгч чадаж байгаа. Жишээ нь 95 хувийн агуулгатай жоншоо 2010 онд тонныг 254-320 ам.доллараар Орост нийлүүлсэн. Түрүү хэлснээр биржийн бус бараа болох учир жоншин дээр дэлхийн тэргүүлэх үйлдвэрлэгч БНХАУ ФОБ үнийг үндэслэн экспортын дундаж үнийг тогтоодог. Английн зах зээл судлалын “Индустриал минерал” компаниас энэ үнийг сар бүр зарладаг, долоо хоног бүр билэнд ирүүлдэг. Бид түүнийг нь таван мянган ам.доллар төлөөд мэйлээр авдаг. Жишээ нь 2010 оны 11, 12-р сарын байдлаар 97 хувийн агуулгатай жоншны баяжмалын дундаж ФОБ Хятадын үнэ дэлхийн зах зээл дээр 290 ам.доллар байна. Гэхдээ энэ үнэ манайд “хорогддог”. Яаж гэхээр бид 95 хувийн агуулгатай жонш гаргаж байгаа болохоор 2 хувийн агуулгын зөрүү гээд 6 доллар хасагддаг. Дараа нь Хятадын Тяньжин портоос Эрээн хүртэл тээвэр, ачиж буух зардал, мөн даатгалын үнэ гээд 35 долларыг хасчихдаг.

Тэгээд Эрээнээс Бор-Өндөрийн тээврийн зардал 8 доллар бас хасагдана. Эргээд ОХУ руу гаргахад Наушк руу ачсаных 16 доллар гээд үндсэн үнэ нь 257 ам.доллар болж байгаа юм. Жоншны үнэ бүрдэх зарчим маш тодорхой, ил тод олон улсын формулаар хийж байгаа юм. Гэтэл хувийн хэвшлийн компаниуд ийм стандарт, формулыг ашигладаггүй. Харин бидний баяжмал экспортлож байгаа энэ үнийг үндэслээд ЭБЭХЯ жоншны жишиг үнэ тогтоочихдог. Яахав тэдний агуулга 75, 85, 92 гэсэн янз бүрийн хувьтай, борлуулах үнэ нь бага байгаа л даа.

ЭБЭХЯ-наа тогтоож байгаа жишиг үнэ (ам.доллар)


Жонш	Флотацийн баяжмал ФФ-97 /Нойтон/	225	АНУ-д экспортлож байгаа үнийн мэдээ /DAF-Эрээн/
	Флотацийн баяжмал ФФ-95 /Хуурай/	254	ОХУ-д экспортлож байгаа үнийн мэдээ /DAF-Наушки/
	Металлургийн баяжмал ФК-75	97.5	Металлургийн баяжмалын үнийг тооцохдоо агуулгын нэгж хувийг 1.3-аар үржүүлэн гаргалаа
	Металлургийн баяжмал ФК-80	104	
	Металлургийн баяжмал ФК-85	110.5	
	Металлургийн баяжмал ФК-92	119.6	
Төмөр	63.5% агуулгатай хүдэр	148	www.metaltorg.ru
	66% агуулгатай баяжмал	91	www.metaltorg.ru

Жишээ нь 75 хувийн агуулгатай металлургийн жоншийг өнөөдөр 90-100 ам.доллараар борлуулж байна. Хувийн компаниудын хувьд ихэнх нь өөрийн орд газаргүй, тэдгээр хувийн компаниуд хувь хүмүүсээс жоншны баяжмал, хүдэр худалдан авч байна. Тэд жоншоо ченжүүдээс аваад хил дээр Орос, Хятадын мөн адил ченжүүдэд 60-80 ам.доллараар хямдхан өгчихдөг. Түүнийг Хятадууд Тяньжиний агуулахад 75, 85 ба 92 хувийн агуулгаар нь түүж ангилаад, цааш нь Япон, Солонгос ба Америк руу гаргаж байгаа. Жоншны худалдаа өнөөдөр ийм л байдалтай байна.

Зэсийн баяжмалын худалдах үнийг тогтоох, гэрээ хийх үйл явц их хэцүү. Өнгөт металл болохоор. Энд зэсийн баяжмал дотор байгаа алт, мөнгө, бусад металл болон хортой элементүүдийг тооцдог. “Эрдэнэт”-ийн зэс нь 24%-ийн агуулгатай, түүнд мөнгө тоннд 70 грамм байдаг, түүнээс дээшийг яг л нөгөө олон улсын формулаар төлдөг. Хортой элемент байлаа гэхэд агуулгыг нь тооцоод 0,2 хувиас дээш бол торгууль тооцож, хасалт хийгээд явдаг. Цэвэр зэсийн үнийг өмнө нь хэлснээр Лондонгийн металлын бирж дээр тогтоодог. Харин зэсийн баяжмалынх нь үнэ зах зээл дээр тогтдоггүй. Хайлах, цэвэршүүлэх зардал- TC/RC гэж олон улсад хэлж

заншсанаар худалдан авагчтай түүний түвшинг тохиролцоо замаар гэрээ хийдэг.

Дэлхийн хайлах үйлдвэрүүдэд зэс хайлах явцад 1-1,2 хувийн үйлдвэрлэлийн алдагдал гардаг. 2010 оны хувьд Чили, Канад, Индонез зэрэг орнуудын зэсийн баяжмал үйлдвэрлэгчид Японы зэс хайлах үйлдвэрүүдтэй тохиролцож гэрээ хийсэн жилийн TC/RC ын дундаж түвшин Японы эрэг дээр СИФ үнээр 46 ам.доллар /тн, 4.6 цент/ фунт байсан.



Уг нь Эрдэнэт үйлдвэр баяжмалаа DAF-Эрээн-Монгол Хятадын хил нөхцлөөр борлуулахдаа Японоос Хятадын порт, Тяньжинээс Эрээн хүртэл тээврийн зардал 75-85 ам.долларыг хасч TC/RC-ыг тооцох ёстой. Хайлах, цэвэршүүлэх зардлыг жилийн, улирлын болон сарын гэх мэтээр 2-3 янзаар тохирч хийдэг. Манай “Эрдэнэт” үйлдвэрийн хувьд гаргаж байгаа 550 мянган тонн баяжмалаа борлуулах гэрээгээ жилээр хийчихдэг. 2010 онд TC/RC-ыг 8.5 ам.доллар /тн, 8.5 цент/ фунт түвшингээр тохирч гэрээлсэн, өөрөө хэлбэл хайлах, цэвэршүүлэх зардлаа ихээхэн өндөр тохирч байгаа, Монголын хувьд ихээхэн алдагдалтай арилжаа хийж байгаа. Олон улсын зэсийн зах зээлийн шинжээчдийн судалгаагаар Эрдэнэт үйлдвэр жилд олон арван сая доллар алдсаар байна.

Зөвхөн зах зээл дээр зэсийн баяжмал илүүдэлтэй байна уу, хорогдолтой байна уу, мөн дэлхийн хэмжээний хайлах, цэвэршүүлэх үйлдвэрүүд хүч чадлынхаа хэдэн хувийг ашиглаж байна, зах зээлийн үнэ хэд байна гэдгээс TC/RC-ын хэмжээ ч хамаардаг.

Энэ бүхнээс үзэхэд манай зэсийн үнэ дийлэнх нь урьд хөрш рүү гарч байгаа учир Хятадын хайлах, цэвэршүүлэх TC/RC-ээр жилийн гэрээгээ хийх, мөн сар ба улирлын спот зэсийн хайлах, цэвэршүүлэх үнээр баяжмалаа борлуулж экспортын орлогоо нэмэгдүүлэх ихээхэн боломж байна. Хятадын үйлдвэрүүдийн хайлах, цэвэршүүлэх зардал дэлхийн түвшингээс байнга бага байдаг.

Үүн дээр баяжмал гаргаж буй үйлдвэр болон худалдан авагчийг дэмжсэн, төлбөрийг ачсан сар, ачсаны дараахь ба 2 дахь сар гэх мэтээр аль нэгийг худалдан авагч сонгож, тэр сарын Лондонгийн биржийн дундаж үнээр төлбөрөө хийдэг. Нөгөөтэйгүүр зэсийн үнэ 1800 доллараас доош байвал баяжмал гаргаж буй үйлдвэрийг, дээш бол худалдан авагчийг дэмжсэн механизм олон улсад мөрдөж байна.

Алтан дээр манайд Гэнэтийн ашгийн 68 хувийн татвар ногдуулчихсан, үүнээс шалтгаалаад өмнө нь жилд 20 орчим тонн алт тушаадаг байсан бол одоо 4,5 тонн болчихсон. Гол олборлогч Канадын хөрөнгө оруулалттай “Бороо гоулд” алтаа Монголбанкинд тушаахгүй, шууд Канад ба Английн цэвэршүүлэх үйлдвэрт явуулж байх жишээтэй. Өнөөдөр хичнээн тонныг ямар агуулгатай алт гаргаж байгааг манай Геологийн төв лаборатори болон Сангийн яамны дэргэдэх “Зоос гоёл”-ын үйлдвэрийн лабораториуд давхар сорцлол хийж байна уу, үгүй юу гэдэг дээр гайхаж байгаа. Харамсалтай нь ганц алт ч бус, зэс болон бусад эрдэс түүхий эд дээр 68 хувийн татварыг төрийн өмчийн “Эрдэнэт” болон “Монголросцветмет” зэрэг улсын үйлдвэрүүд төлөөд байхад Тогтвортой байдлын гэрээтэй “Цайрт минерал”, газрын тосны аж ахуйн нэгжүүд төлөхгүй байгаа. Оюутолгой ч Монголын Засгийн газартай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний дагуу чөлөөлөгдөж байгаа.